

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2022 оны 12 дүгээр сарын 15-ны өдөр
Хурал хуралдсан газар: Сангийн яамны хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 9 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн хувийн хэвшлийг төлөөлөх гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сунгав.

Хоёрдугаар асуудал. Монголын МСС УТҮГ-ын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав.

Гуравдугаар асуудал. Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирал болон Захиргааны асуудал хариуцсан ахлах ажилтныг томилло.

Дөрөвдүгээр асуудал. Монголын МСС-ийн Дотоод аудитын стратегийн тодотгосон төлөвлөгөө болон 2023 оны төлөвлөгөөг батлав.

Тавдугаар асуудал. Монголын МСС-ийн Хөтөлбөрийн удирдлагын тогтолцоо, арга хэрэгсэлд хийсэн судалгааны дүн, тайлантай танилцав.

Зургаадугаар асуудал. Монголын МСС-ийн нийцлийн чиг үүргийн бүтэц, хэрэгжилтэд хийсэн судалгааны дүнтэй танилцав.

Долдугаар асуудал. Хөндлөнгийн хараат бус аудитын 2022 оны тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх багц ажлын төлөвлөгөөг батлав.

Наймдугаар асуудал. Монголын МСС-ийн Эрсдэлийн удирдлагын асуудалтай танилцав.

Есдүгээр асуудал. Бусад.